



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 460

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Стандарт, хэмжил зүйн газрын Тамгын газрын дарга Б.Эрдэнэзул, Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002341



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2018 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн
 460 дугаар тогтоолын хавсралт

**ХОВД АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН**

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Худалдах доод үнэ		
							(төгрөг)	(төгрөг)	
1	УАЗ 22069 фургон суудлын автомашин, арлын дугаар 374100С0473625,22-04 ХОУ	2012/2012	81,500	22,000,000.00	22,000,000.00	-	1,000,000.00		
НИЙТ ДҮН								1,000,000.00	(нэг сая)
				(хорин хоёр сая)	(хорин хоёр сая)	-			